

## **“АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД**

Гүйцэтгэх захирал Х.Ханиягаас тавих тайлан

### **Илтгэл**

“Ариг гал” ХК–ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг эрин мэндчилье. Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас хийсэн ажлын тайланг Та бүхний сонорт хүргэх ялдамд цаашид ямар зорилго тавьж байгаагаа хүргэе.

### **Нэг. Борлуулалтын орлогын талаар**

Тайлангийн хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн өмнөх хурлаас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд дараах үйл ажиллагаагаа зохицуулан явууллаа. Тайлангийн хугацаанд 10,908.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөнөөс 26,5%-иар давуулан биелүүлж 13,802.5 сая төгрөгийн орлоготой ажиллалаа. Үүнд:

1. Зарим барилга хөрөнгөө түрээслүүлсний орлого төлөвлөгөөнөөс 7,5%-иар өссөн. Өмнөх оноос 12,8%-иар буурсан. Харин “Таван толгой” ХК-иас манай хувь оролцоонд ногдол ашиг өмнөх оноос 31,5%-иар нэмэгдэж 12,6 тэрбум төгрөг орж ирсэн нь дээрх бууралтыг бүрэн нөхсөн.
2. Бусад орлогын хувьд харилцах дансанд байгаа мөнгөө түр хугацаагаар хадгаламжинд хадгалуулснаар хүүгийн орлого өмнөх онтой харьцуулахад 3,8 дахин өсч 49,2 сая.төг олсон. Компанийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд ноосны үйлдвэрлэлийн үед хэрэглэж байсан илүүдэл сэлбэгүүдийг ангилан 38,0 сая төгрөгийн сэлбэг зарсан бөгөөд цаашид хивсний үйлдвэрүүд үргэлжлүүлэн сэлбэг авахаар тохиролцоод байна.
3. Компанийн хашаанд хуримтлагдсан хаягдал төмрийг компаниас зардал гаргахгүйгээр хамгийн өндөр үнээр зарж 52,3 сая төгрөгийн борлуулт хийсэн.
4. Түрээсийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд машины зогсоолоо түрээсэлж 16,0 сая төгрөгийн орлого оруулснаас гадна манай инженерийн шугам сүлжээ ашиглаж байгаа компаниудын ашиглалтын төлбөрийг нэмэх санал боловсруулж холбогдох тохиролцоонд хүрсэн ба энэ оноос хэрэгжүүлэхээр зорьж байна.
5. Компанийн барилгын дээврийг оросын алдартай брэнд техникель буюу орчин үеийн чанартай урлон материалаар 10900 м2 дээврийг 196,0 сая төгрөгөөр засаж олон жил ашиглаж чадаагүй энэхүү байрыг цаашид бизнесийн үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой болгосон. Энэ нь орлогоо өсгөхөд эерэг нөлөөлөх болно. Ийнхүү нийт дүнгээрээ хувьцаат компанийн орлогын төлөвлөгөө давж биелсний үр дүнд компаний ашиг үр дүн, хувьцааны ногдол ашиг урьд оноос өсч гарлаа..

### **Хоёр. Зардлын талаар**

2024 онд үндсэн үйл ажиллагаанд 1,890,9 сая.төг-ийн зардал гарсан нь өмнөх онтой харьцуулахад өсөөгүй. Үйл ажиллагааны бус зардал өмнөх оноос 4,4%-иар өссөн. Энэ нь

валютын ханшны өсөлтөөс гадна газрын маргааны асуудлыг шийдэхэд багагүй хүч хөрөнгө, мэргэжлийн өмгөөлөгч, хуульч нарыг татан оролцуулахад багагүй зардал гарсан болно.

### Гурав. Ашгийн талаар

2024 оны тайлан балансын дүнгээр нийт 4,1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Үүнээс холбогдох татвар 1,2 тэрбум төгрөгийг төлж, 2,7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн бусад тайлангуудаар НӨАТатвар, ХАОАТ болон Хүүгийн орлогын татваруудыг тайлагнаж төлсөн.

“Ариг гал” ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт 1,645.9 сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн. Үүнд:

НӨАТатварт - 111.4 сая төгрөг,  
 НДШимтгэлд - 65,7 сая.төгрөг,  
 Газрын төлбөрт - 85.2 сая төгрөг,  
 ҮХХТатварт - 42.6 сая төгрөг,  
 ХАОАТатварт - 72.1 сая төгрөг  
 Хүү болон Ногдол  
 ашгийн орлогын татварт - 1,268.9 сая төгрөг тус тус төлсөн.

2023, 2024 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл болон 2025 оны төлөвлөлтийг харуулбал:

№	Үзүүлэлт	2023 оны		2024 оны		Төлөвлөгөөнөөс өсөлт, бууралт		2025 оны төлөвлөгөө
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	Дүнгээр	%-иар	
1	Борлуулалтын орлого	5,965,000.0	4,465,674.6	5,644,955.7	6,072,202.3	427,246.6	7,5	10,946,059.5
	Үүнээс:түрээсийн	750,000.0	1,277,651.1	1,280,000.0	1,113,583.2	-166,416.8	-12,8	1,280,000.0
	Бусдаас авсан ноогдол ашиг	5,200,000.0	10,635,380.1	9,613,155.7	12,639,791.2	3,026,635.5	31,5	14,916,059.5
	Бусад орлого	15,000.0	13,147.0	15,000.0	49,221.1	34,221.1	3,2 дахин	50,000.0
2	Нийт зардал	2,584,424.0	9,416,802.8	8,397,624.0	9,721,584.1	1,323,960.1	15.7	7,970670,800.0
3	Нийт ашиг	3,380,576.0	2,509,375.4	2,510,531.7	4,081,011.4	1,570479.7	62.6	2,975,259.5
	Ашгаас санхүүжих зардал	15,000.0	4,085.0	15,000.0	33,997.3	18,997.3	2,2 дахин	
	ААНОАТ	200,000.0		200,000.0	1,268,901.2	1,068,901.2		
	Цэвэр ашиг	3,165,576.0	2,505,290.4	2,295,531.7	2,778,112.9	482,581.2	21,2	2,975,259.5

### Дөрөв.Санхүүгийн байдлын талаар

2024 оны тайлан балансыг харахад авлага өмнөх оноос 22,2%-иар өссөн. “Кашмер холдинг” ХХК-иас авах авлага 14,3 тэрбум төг-өөр өссөн. нийт авлага 78,1 тэрбум.төг болсон нь түүхий эдийн санхүүжилтээс шалгаалсан.

Өглөгийн хувьд өмнөх оноос 15,2%-иар өссөн нь “Мон ноос” ХК-иас авсан зээлийн өглөг юм. Энэ нь дээр хэлснээр түүхий эдийн бэлтгэлтэй холбоотойгоор охин компанийн эргэлтийн хөрөнгийн санхүүжилтанд олгосон.

**“Ариг гал” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн хураангуй БАЛАНС /мян.төг/**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл		Өсөлт бууралт	
	2023.12.31	2024.12.31	дүнгээр	хувиар
<b>А.ХӨРӨНГӨ</b>				
1. Эргэлтийн хөрөнгийн дүн	66,901,116.9	80,826,596.4	13,925,479.5	20.81
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,020,640.5	1,556,016.7	(464,623.8)	(22.99)
Авлага	64,853,538.5	79,243,653.5	14,390,115.0	22.19
Үндсэн туслах материал	26,937.9	26,926.2	(11.7)	(0.04)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо				
2. Биет хөрөнгийн дүн	2,419,355.1	2,296,583.1	(122,772.0)	(5.07)
3. Биет бус хөрөнгийн дүн	524,327.5	522,691.7	(1,635.8)	(0.31)
4. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	18,344,003.6	18,474,485.5	130,4581.9	0.71
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>88,188,803.2</b>	<b>102,120,356.7</b>	<b>13,931,553.5</b>	<b>15.80</b>
<b>Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧД- ӨМЧ</b>				
1. Өр төлбөрийн дүн				
Богино хугацаат өр төлбөр	74,324,624.5	85,671,726.5	11,347,102.0	15.27
Урт хугацаат өр төлбөр /ногдол ашгийн өглөг/	950,407.4	1,153,229.9	202,822.5	21.34
Үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр				
2. Хувьцааны дүн	347,932.0	347,932.0	0	
Халаасны хувьцааны дүн	(21.469.3)	(25,890.8)	(4,421.5)	20.59
3.Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,289,099.1	6,154,696.4	(134,402.7)	(2.14)
4. Хуримтлагдсан ашиг	3,792,819.1	6,040,549.8	2,247,730.7	59.26
Тайлант үеийн ашиг	2,505,390.3	2,778,112.9	272,722.6	10.89
5. Эзэмшигчийн өмчийн дүн	12,913,771.3	15,295,400.3	2,381,629.0	18.44
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>88,188,803.2</b>	<b>102,120,356.7</b>	<b>13,931,553.5</b>	<b>15.80</b>

**Орлогын тайлан /мян.төг/**

Санхүүгийн үзүүлэлт	Орлогын тайлан		Өсөлт бууралт	
	2023.12.31	2024.12.31	дүнгээр	хувиар
Борлуулалт	1,277,651.1	1,113,583.2	(164,067.9)	12.8
<b>Ашиг</b>	<b>1.277.651.1</b>	<b>1,113,583.2</b>	<b>(164,067.9)</b>	<b>12.8</b>
Үйл ажиллагааны зардал	1,890,177.9	1,890,926.7	748.8	0.04
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	4,296,531.2	4,824,357.6	527,826.4	12.2
Үүнд: Ногдол ашгийн орлого	11,812,533.5	12,639,791.2	827,257.7	7.0
Хүүгийн орлого	14,607.7	49,221.1	34,613.4	
Валютын ханшийн ашиг алдагдал	(7,460,503.6)	(7,730,393.2)	(269,889.6)	3.6
Үйл ажиллагааны бус зардал	(70.106.4)	(134,261.5)	(64,155.1)	91.5
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>3,684,004.5</b>	<b>4,047,014.1</b>	<b>363,009.6</b>	<b>9.8</b>
Татвар	1,178,614.1	1,268,901.2	90,287.1	7.6
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,505,390.3</b>	<b>2,778,112.9</b>	<b>272,722.6</b>	<b>10.8</b>

**Тав. 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн  
зорилтын биелэлтийн талаар**

“Ариг гал” ХК-ийн бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулах ашигт ажиллагааг өргөжүүлэхийн тулд барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнд КХ ХХК-тай хийсэн ашиглалтын гэрээний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Компанийн барилгын дээврийг урьд ярьснаар техниконикелийн материалаар 10900м<sup>2</sup> талбайг 196,0 сая төгрөгөөр засуулж, дээврийн засварыг хүлээж авлаа.
2. Бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд Ариг гал ХК-ийн инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийн насжилтыг уртасгах, аюулгүй ажиллагаа гэнэтийн эвдрэл, осол гаргахаас урьдчилан сэргийлж төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээг 60,0сая.төг-өөр мэргэжлийн өндөр түвшинд хийлгэж актаар хүлээж авсан.
3. Компанийн барилгын баруун талын цонхонд конденсац үүсэж барилга нурах, дулаан алдаж байсныг засаж цонхнуудын амалгаануудыг сольж, цонхыг вакумжуулснаас гадна барилгын өрлөгийг шинээр хийж хэвийн болгохын тулд 19,0сая.төг-ийн засвар үйлчилгээ хийж дуусгаснаар Хавт шонхор ХХК, Эвсэг од ХХК-иудын үйлдвэрлэлийн ажиллах нөхцлийг сайжруулж дулаан алдагдалгүй болгосон.
4. Гадаад дотоодын жуулчид болон монголын хэрэглэгчдээ тав тухтай хүлээн авахын тулд Худалдааны төвийн дулаан алдагдлыг багасгах, 00-ын агааржуулалтыг шинэчлэх, ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулахад 26,0сая.төг-ийн засвар үйлчилгээг хийлгэсэн.
5. Төрийн байгууллагаас манай компанийн эзэмших эрх бүхий газар дээгүүр зам барихаар төлөвлөж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд газар эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг үл ойшоож манай 5 газрын эрхийг шууд хүчингүй болгож өөрсдийн хууль бус шийдвэрээ хүчээр тулгах, компанийн үйл ажиллагаанд зориуд саад учруулах, ажил хэргийн нэр хүндэд халдсан санаатай үйлдлүүд гарсныг таслан зогсоохын тулд 3 газрын асуудлыг шүүхэд өгч маргаанаа хуулийн дагуу шийдүүлж газар эзэмших эрхээ сэргээж авсан. Бусад газартай холбоотой асуудлыг Нийслэлийн газар зохион байгуулалтын газартай 2 талаасаа зөвшилцсөний үндсэн дээр компанийн баруун талын 2990 м<sup>2</sup> газрыг буцаан авч Нийслэлийн засаг даргын захирамжийг гаргуулж авлаа. Нийгмийн хариуцлагын хүрээнд түгжрэлийг бууруулах зорилгоор компанийн баруун талаас 2011м<sup>2</sup> газарт зам тавиулж энэ газраа нөхөн авах тохиролцоог ярилцаж байгаа бөгөөд энэ онд газартай холбоотой асуудлуудад маш их цаг хугацааг зарцуулж туршлагатай хүмүүс, өмгөөлөгч, хуульч нарыг ажиллуулан үр дүнд хүрлээ.
6. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагааг дэмжиж ажиллах нөхцлийг сайжруулж түүхий эд бэлэн бүтээгдэхүүнүүдийн агуулахуудыг томсгож агуулахын техникийн шаардлагыг хангаж ажиллах зорилгоор бэлтгэл цехийн 3366м<sup>2</sup> талбайд байрлаж байсан тоног төхөөрөмж лабазуудыг буулгаж илүүдэл сэлбэгийг гаргаж борлуулснаар зай талбайг нь чөлөөлж ашиглахаар боллоо.
7. Шинэ бизнес эхлүүлэхийн тул туршилтын үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд гаднаас туршлагатай зөвлөхүүд, дизайнеруудыг ажиллуулж Америк, Япон, Солонгос, Англи, Герман, Хятадын зах зээлд онлайн худалдаа болон дэлгүүрийн франчайзнаар дэлгүүр туршилтаар ажиллуулж эхлүүлсэн. Шинэ ноолууран бүтээгдэхүүний жинг хөнгөрүүлж нарийн номерын утсаар нэхмэл, сүлжмэл хийлгэх, үндэсний хувцас үйлдвэрлүүлэх, хоёрдогч түүхий эд ашиглан шинэ бүтээгдэхүүн хийлгэх зэрэг ажлуудыг

- туршилтаар хийж байгаа бөгөөд судалгааны ажил үргэлжлүүлэн дүгнэлт гаргаж 2025 онд шинэ брэнд гаргах ажлыг эхлүүлнэ.
8. 2024 онд КХ ХХК-ийн хялгас ялгах үйлдвэрлэл жигдэрсэн тул 2025 онд хялгасыг ялгасан ноолуурыг экспортолж ашиг орлогоо нэмэгдүүлж ажиллана.
  9. Ариг гал ХК нь түүхий эд авахын тулд зээл авах, нөхцлийг бүрдүүлж компанийн үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж эргэлтийн хөрөнгийн зээлийг авч өгч дэмжлэг туслалцаа үзүүлсний үр дүнд КХ ХХК 2024 онд 233,2тн ноолуурыг 36,9 тэрбум₮-өөр худалдан авснаар хялгас ялгах 25,5%-иар, ээрэх 27,6%-иар, сүлжих 5,6%-иар, нэхэх 28,8%-иар үйлдвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлснээр борлуулалт 12%-иар өссөн.
  10. Компанийн хэмжээнд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхийн тулд:
    - а. Компанийн ажилтнуудын ажиллах нөхцлийг хангахын тулд ХУД-ийн 27-р цэцэрлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 45 хүүхдийг цэцэрлэгт хамруулсан. Компани 2025 онд ажилчдын хүүхдийн цэцэрлэгийг өөрийн байранд ажиллуулахын тулд барилгын засвар агааржуулалтын асуудлыг шийдэхээр төсөв, төлөвлөгөө гаргаад ажиллаж байна.
    - б. “Ариг гал” ХК болон үйлдвэрлэлийн компаниудын ажилтнуудад нийт 24 ажилтанд орон сууцны урьдчилгаанд хамруулж 664,0 сая төгрөгийн зардал гаргасан.
    - в. ҮК-иудаас сонгон шалгаруулж 3 ажилтанг ШУТИС-д 9,4 сая төгрөгөөр сургаж байна.
    - г. Гаднаас 4 менежменттэй холбоотой сургалт авахад 8,0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.
    - д. Нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэхээр 29 ажилтанд 18.3 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүллээ.
    - е. Компанийн ажилтнуудын ажлын үр дүн, шинэ санаа, ажлын гүйцэтгэлийн чанарыг сар бүр багаар хэлэлцүүлж 239,4 сая төгрөгийн урамшуулалыг олгосон байна.
    - ё.. Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум үндэсний санаачлагыг дэмжин Өмнөговь аймгийн засаг даргын ивээл дор тус аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг уриалан амь чийгтэй говийн бүрдүүдийг түшиглэн ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАХ ЭВИЙН ТӨГӨЛ төслийг Ариг гал ХК-ийн ТУЗД санаачлан хэрэгжүүлж, сум бүрт ногоон төгөл байгуулж цөлжилтөөс хамгаалж ургамлын бүрхүүл, санг хамгаалах баяжуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг уялдуулах байнгын бүтэц схемтэй болгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцон хамтран ажиллаж байна. Энэ нь ТТ ХК нь үр дүнтэй ажиллаж, ногдол ашиг өсөхөд эерэг нөлөөлсөн.

### **Зургаа. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар**

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэц-д өөрчлөлт ороогүй, ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА, Гүйцэтгэх удирдлага гэсэн бүтцээрээ ажиллаж байгаа.

“Ариг гал” группийн хэмжээнд “Ариг гал” ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, “Кашмер ходдинг” ХХК-иуд үйл ажиллагаагаа явуулсан хэвээр байна.

“Кашмер холдинг” ХХК-ийн охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн “Хавт шонхор” ХХК, сүлжих үйлдвэрлэлийн “Монмяндас” ХХК, нэхэх үйлдвэрлэлийн “Эвсэг од” ХХК, ширмэл үйлдвэрлэлийн “Тансаг ширээс” ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн “Говийн мяндас” ХХК, борлуулалтын “Эвсэг” ХХК-иуд үйл ажиллагаа явуулж байгаа.

Эдгээр Компаниудын ажлыг сар бүр ТУЗ-д туслах чиг үүрэгтэй ТУЗ-ийн даргын АА нь дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах, сүүлийн байранд орсон компанийн удирдлагад хариуцлага тооцох асуудлыг ТУЗ-ийн даргад тавьж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулах зорилгоор шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, тус шалгуур үзүүлэлтээр компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулан ажилласан. “Ариг гал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулан бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого, удирдлагаар хангаж ажилласан.

### **Долоо. Сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн талаар**

Тус компани нь Группийн толгой компанийн үндсэн үүргээр ноолуурын үйлдвэрлэлийн охин компаниуддаа ноолуур бэлтгэлийн эргэлтийн хөрөнгө, үйлдвэрлэл өргөтгөх, технологийн сайжруулалт, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх үйл ажиллагааны санхүүжилтэд нь зориулж бусад байгууллага, банк, ББСБ-аас зээл олж өгөх, зээлд хөрөнгийн барьцаа, батлан даалт гаргах зэргээр эх орныхоо “сэргээгддэг баялаг” болсон Монгол ямааны ноолуурын боловсруулалтын үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг дэмжих зохицуулалт бүхий бодлогыг баримталж, хэрэгжүүлж ажиллаж ирсэн.

Тус компанийн ТУЗ-ийн гишүүдийн 55.5% нь өөрийн охин компани болох Кашмер холдинг ХХК-иас сонгогдсон гишүүд байгаагаас дээрх бодлогын хүрээнд охин компаниудад үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх ТУЗ-ийн шийдвэр нь “Компанийн тухай хууль”-ийн 89.1.3 дугаар зүйлд зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдож байгаа болно.

Иймд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хурлын хараат бус гишүүдийн 100%-ийн саналаар 05.23 тоот тогтоол гарч, Мон ноос ХК-иас зээл авах зөвшөөрөл олгож, 19.0 тэрбум /арван есөн тэрбум/-төгрөгийн зээлийг “Кашмер холдинг” ХХК-ийн түүхий эдийн, Хавт шонхор ХХК-д тоног төхөөрөмжийн зээл олгож, зээлийн эх үүсвэрээр үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж технологи хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

### **Найм. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь**

Одоогийн байдлаар компанийн 3749320ш хувьцааг 7270 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа нь өмнөх оноос 1,3%-иар хувьцаа эзэмшигчдийн тоо буурсан нь хувьцааны төвлөрөл үргэлжилж байгаа гэж харж байна. Компани нь халаасны хувьцааг 9,4%-иар нэмэгдүүлсэн өнөөдрийн байдлаар 3,6%-ийг халаасалсан байгаа.

Тус компанийн хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харъяа компаниудад ажилладаг ажилтнууд байгаа. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшиж байгаа хэвээр.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн, МХБ-ийн веб сайтад байршуулж нийтэд мэдээлэгдсээр ирсэн. Компанийн хувьцааны 44.0%-ийн хувьцаа нь 7269 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байна

## **Ес. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.**

ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлаас 2023 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн 11.13%-иар буюу нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийг 80.00 төгрөгөөр (наян төгрөг 00 мөнгө)-өөр, буюу нийт 278345.6 мянган төгрөг (хоёр зуун далан найман сая гурван зуун дөчин таван мянгазургаан зуун)-ийг хуваарилсан.

ТУЗ-ийн 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хурлаас 2024 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн 13%-иар буюу нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийг 100.00 төгрөгөөр (нэг зуун төгрөг 00 мөнгө)-өөр, буюу нийт 361,154.7 мянган төгрөг (гурван зуун жаран нэгэн сая нэг зуун тавин дөрвөн мянга долоон зуун) -ийг хуваарилахаар шийдвэр гаргасан байна.

## **Арав. Цаашид хийх ажил**

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэхийн тулд үйл ажиллагаа, менежмент үр ашгийг дээшлүүлэхийн тулд АГ ХК-ийн ТУЗД-ын дэргэдэх Ажлын албаар дамжуулан хяналт тавьж мониторинг хийж ажлыг үр дүнд хүргэж ажиллана.
2. Компанийн үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг хамгаалах, ашиглалтыг сайжруулах алдагдах эрсдлээс хамгаалах ажлыг Ажлын албан дээр төвлөрүүлэн хяналт тавьж ажиллана.
3. Үйлдвэрлэлийн компаниудын бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулэхын тулд үлд хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж эргэлтйн хөрөнгийн зээл авахад дэмжлэг үзүүлж ажиллана.
4. Ариг гал ХК болон охин компаниудын газартай холбоотой маргаантай асуудлыг компанид хохиролгүйгээр эцэслэн шийдвэрлэж дуусгах.
5. Үйлдвэрийн баруун талын 290 м2 газрыг 1992 онд алдсан байсныг буцаан авч ажилчдын машины зогсоолоор тохижуулан ашиглаж эхлэх.
6. Ариг гал ХК шинэ бизнесийг эхлүүлэхийн тулд геологийн гавъяат ажилтан Цэдэнбалжир зөвлөхөөр үнэт металлын хайгуулын судалгаа болон цэвэр ус савлах төслийг боловсруулж судалгааг хийлгэж, цэвэр ус савлах ажлын байрны засварын ажлыг эхлүүлэх.
7. Төв аймгийн Баян сумын нутагт байгаа шохойн ордны ТЭЗҮ, Байгаль орчны төлөв байдлын суурь үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчны нарийвчлалын төлөвлөгөөг орон нутагтай тохирч мэргэжлийн яам, агентуудаас албан ёсны зөвшөөрөл, баркодыг авч дуусгаад энэ оноос албан ёсоор ажиллуулах эрхээ авсан. Шохойн ордыг аман дээрээс нь борлуулахаар ТЭЗҮ-гээ хийлгэсэн. Гэвч шохойн чулууг буталж зарах, эсвэл ордоо шууд зарж борлуулбал зах зээлд ямар үнэ хүрч болох талаар судалгаа явуулсан, тэрчлэн цаас хийж борлуулах төслийн судалгаануудыг хийлгэсэн. Судалгааны дүгнэлтээс харахад Шохойн ордыг түрээсийн тоног төхөөрөмжөөр ажиллуулахад эрсдэлтэй байгаа тул цаашид үргэлжлүүлэн судлах шаардлагатай байна.
8. 2024 онд хийгдэж эхэлсэн шинэ бизнес ус савлах, хүргэлийн үйл ажиллагаа явуулах, нөрийн номерын утсаар бүтээгдэхүүн хийх, үндэсний хувцас хийх, хүүхдийн хувцасны брэнд гаргах ажлыг дэмжиж зарим ажлыг хариуцан үр дүнд хүргэж ажиллах.
9. Нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн цэцэрлэгтэй болгох, ажилчдыг тав тухтай эрүүл орчинд ажиллуулахын тулд агааржуулалт, гэрэлтүүлэг, ажлын байрны

тохижилтыг сайжруулах, нойлын асуудлыг шийдэх, машины зогсоолын асуудлыг бүрэн шийдэхэд дэмжлэгэ туслалцаа үзүүлж ажиллах.

10. Ажилчдыг орон сууцтай болгохын тулд орон сууцны урьдчилгааг олгуулах, буцалтгүй тусламж үзүүлэх ажлыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх ажиллагааг зохион байгуулах.
11. АА-ны харъяа компаниудын менежментийг сайжруулахын тулд нэгдсэн сургалт зохион байгуулах, ажилтнуудыг их, дээд сургуулиудад суралцуулах ажилд идэвхтэй оролцож санхүүжүүлэх.

Хүндэтгэсэн: Гүйцэтгэх захирал /  - Х.Хания

